



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/12

Хужирт сум

Иргэнд өмчлүүлсэн газарт  
нийтийн сервитут тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.4 дэх хэсгийг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

- Инженерийн шугам сүлжээ /бохир усны/ байгуулах зорилгоор Хужирт сумын 4 дүгээр багийн Өвгөн жалгын 394 тоот хаяг байрлалтай иргэн Нямбатын Батзаяа (ЧД81013115)-д өмчлүүлсэн нэгж талбарын 141900734 дугаартай 1543.5 метр.кв газрын 508.5 метр.кв талбайд байнгын, нийтийн сервитут тогтоосугай.
- Нийтийн сервитут тогтоосон газрын кадастрын зургийг хавсралтаар баталсугай.
- Батлагдсан газрын кадастрын зургийг Газрын удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэхийг газрын даамал (Ц.Нямдорж)-д даалгасугай.
- Өмчилсөн газраа ашиглахад хүндрэл бэрхшээлтэй болсон тул иргэн Нямбатын Батзаяа (ЧД81013115)-ийн нэгж талбарын 141900734 дугаартай газар дээр 508,5 метр.кв газрыг нэмж 2052 метр.кв болгон өмчилсөн газрын мэдээллийг өөрчилсүгэй.
- Нийтийн сервитут тогтоосон талбайд үл хөдлөх хөрөнгө барих болон инженерийн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг алдагдуулах үйл ажиллагаа явуулахгүй байхыг иргэн Н.Батзаяад даалгасугай.
- Дээрх захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2006 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 94 тоот “Газар өмчлүүлэх тухай” захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМОНХ

62221023